

**ТӨВ АЙМГИЙН 2022 ОНЫ 07 ДУГААР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ**

2022 оны 08 сарын 05-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2022 оны 07 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас 7 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

“Орон нутгийн сан байгуулж, журам батлах тухай” Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05-р сарын 19-ны өдрийн 09-р Хуралдааны 04 дүгээр тогтоолоор баталсан журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Гэвч тус яамнаас уг журмыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх талаар зөвлөмж, чиглэл ирсэний дагуу дахин боловсруулах талаар аймгийн Засаг даргад 2022 оны 175 дугаар албан бичиг хүргүүлэн бэлтгэл ажлыг ханган, 9-р сард аймгийн ИТХ-ын 11 дүгээр Хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Аймгийн ИТХ-аас 2022 оны 176 дугаар албан бичгээр сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хандан Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хууль хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, тулгамдаж байгаа асуудалд судалгаа дүгнэлт хийн, санал, тайлбарын талаар санал авахаар хүргүүлсэн. Сумын ИТХ, Засаг дарга нараас ирүүлсэн саналд тулгуурлан Ажлын албанаас боловсруулалт хийн холбогдох байгууллагад гарсан саналыг уламжлах юм.

Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 62 дугаар тэмдэглэлийн холбогдох заалтын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлтийг тооцов. Үүнд:

1.1.Эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан хянахад:

-Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд хувь хэмжээ “0.6-1.0” гэснийг “0.6-2.0” гэж дээд хязгаарыг нэмсэн. Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоож, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэн 2018 оны “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай” 09 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон. Улсын нэгдсэн санд бүртгэлтэй тогтоолыг шинэчлэн баталж, хүчингүй болгосон боловч шийдвэрийг тухай бүр холбогдох захиргааны байгууллагад хүргүүлж, өөрчлөлтийг хийлээгүйгээс захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэлтэй хэвээр байна.

-Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /2015.06.11-ний өдөр/ хуулиар 1/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг өөрчлөн найруулсантай холбоотой Төв аймгийн ИТХ-ын 2018.02.06-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг баталсан байна.

-“Тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай” 2018.07.04-ны өдрийн 07 дугаар тогтоолыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 2021.07.07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтийн дагуу хувь хэмжээг шинэчлэн батлах шаардлагатай болсон. Хуулийн өөрчлөлтийг 2022.01.01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлсэн.

-Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг 2021.07.07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулж албан татвар ногдуулах хэмжээ өөрчлөгдсөн хэдий ч “Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг тогтоох тухай” Төв аймгийн ИТХ-ын 2018.07.04-ны өдрийн 08 дугаар тогтоол хуулийн өөрчлөлттэй зөрчилдөөгүй байна.

-“Төлбөрийн хэмжээ тогтоох тухай” ИТХ-ын 2018.07.04-ны өдрийн 10 дугаар тогтоол нь 2017.05.11-ны өдөр шинэчлэн найруулагдаж батлагдсан Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасныг үндэслэн тогтоосон байна.

-2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр шинэчлэн найруулж батлагдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “бичил худалдаа, ажил үйлчилгээ эрхлэгч гэж” ажлын байр лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй худалдаа, үйлчилгээ, зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч хувь хүнийг ойлгоно гэж заасан бөгөөд хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т сард төлөх албан татварын хэмжээг аймаг, нийслэлийн ИТХ энэ хуульд заасан хязгаарт багтаан тогтоохоор зохицуулсан. Дээрх зохицуулалтын дагуу Төв аймгийн ИТХ-ын 2018.07.04-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Бичил худалдаа, ажил үйлчилгээний орлогын албан татварын хэмжээг тогтоосон.

1.2. Ач холбогдолоо алдаж, дагаж мөрдөхөө больсон, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хүчингүй болгох дүгнэлт гаргаж ирүүлсэн шийдвэр байхгүй байна.

1.3. Өөрийн салбарт дагаж мөрдөгдөж байгаа хуулиудаас тусгайлан эрх олгогдсон заалтын судалгааг гарган, батлах зориулалттай боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж тэдгээрийг батлах, бүртгүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

-Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 764 хуульд шинжилгээ хийхэд Аймгийн ИТХ-ын эрх үүргийг заасан 113 хуулийн 499 заалт, Тэргүүлэгчдэд эрх олгосон 16 хуулийн 66 заалт, Ажлын албаны хэрэгжүүлэх 20 хуулийн 152 заалт байна. Үүнээс ИТХ-ын төлөөлөгч 28 чиг үүрэг, ИТХ-ын дарга 14 чиг үүрэг, ИТХ-ын Нарийн бичгийн дарга болон Ажлын алба 26 чиг үүрэг хэрэгжүүлэхээр заажээ.

-Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр даган мөрдөж байгаа 114 тогтоол байна. Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хүрээнд тогтоолуудыг шинэчлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Бусад ажлын хүрээнд:

Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол Улс байгуулагдсаны 815, 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Төв аймаг байгуулагдсны 99 жил, Зуунмод сумын үүсэн байгуулагдсны 80 жилийн түүхт ойг тохиолдуулан аймгийн баярын наадмын хурлыг 2022 оны 07-р сарын 08-ны өдөр Монгол туургатан театрт зохион байгуулж төрийн дээд одон медаль, салбарын шагнал гардуулав.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 123 дугаар зарлигаар шагнагдсан иргэдэд төрийн дээд одон медаль гардуулах ёслолын ажиллагааг зохион байгууллаа.

Төрийн дээд одон медалиар шагнагдсан иргэдийн шагналыг аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, Засаг дарга Д.Мөнхбаатар, Монгол улсын Ерөнхийлөгчийн хот хөдөөгийн бодлогын зөвлөх О.Буяннэмэх нар гардуулав.

Энэ үеэр аймаг, орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болсон Хөдөө аж ахуй, Эдийн засаг, Нийгэм, Дэд бүтэц, Төр, захиргааны олон жил үр бүтээлтэй ажилласан хүмүүсийг Монгол улсын Төрийн дээд одон медаль болон салбарын тэргүүн, аймгийн ИТХ-ын шагналаар шагнаж урамшууллаа.

7 дугаар сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 18 албан бичиг ирснийг бүртгэн, аймгийн ИТХ-ын дарга болон нарийн бичгийн даргад танилцуулан, хариу өгөх шаардлагатай 1 бичгийн хариуг өгч ажиллалаа.

Аймгийн ИТХ-ын дарга, Хурлын Ажлын албанаас Ерөнхийлөгчийн Тамгын газар, салбарын яамдуудад болон холбогдох албан байгууллагад 16 бичиг гарган хүргүүлээд байна.

Энэ сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 4 өргөдөл бүртгэгдсэн. Үүнд: Зуунмод сумын 1 иргэнээс цагаатгах ажлын нөхөн олговор авах тухай, ажил хүссэн тухай, Баян сумын нэр бүхий иргэдээс орон сууцны асуудлын тухай, Жаргалант сумын иргэнээс газрын асуудлын тухай өргөдлийн хариуг хуулийн хугацаанд багтаан хариуг өглөө.

Бусад үйл ажиллагааны хүрээнд:

УИХ-ын гишүүн Н.Энхболд орон нутагт ажиллан иргэдтэй хийсэн уулзалтаар Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах дараах 4 чиглэлээр цаазын ялыг сэргээх, сумын Засаг даргын иргэдээс сонгох, УИХ-ын гишүүдийн тоог нэмэгдүүлэх, Төрийн сүлдийг өөрчлөх саналыг авч ажилласан байна.

Батсүмбэр сумын 07 дугаар сарын 7, 8-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэх 98 жилийн ойн баяр наадмын үйл ажиллагаа зохион байгуулагдаж төр засагт олон жилийн ажилласан ахмад настануудыг ардын хувьсгалын 100 жилийн ойн медалиар шагнагдсаныг гардуулан өгсөн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэлмэгдэгсдийн дурсгалд зориулан мод тарих аяны хүрээнд 29 ш мод тарьж, дурсгалыг хүндэтгэх 60х60 хэмжээтэй самбарыг байрлуулсан. Төлөөлөгчдийн ажиллах хуваарь гарган тарьсан мод бутыг арчлах ажлыг хийж гүйцэтгэжээ.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 07 сарын 04, 18-ны өдрүүдэд танхимаар 2 удаа зохион байгуулж, тэмдэглэлээр 35 заалт бүхий үүргийг холбогдох байгууллага, суманд хүргүүлж, хэрэгжилт тооцов.

“Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-д туссаны дагуу 07 сарын 06-ны өдөр “Иргэдтэй уулзах цаг” зохион байгуулж, аймгийн Засаг даргын орлогч Г.Сурмаа иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, хариулт өгөв. Уг арга хэмжээний үеэр иргэдээс гарсан 13 санал, хүсэлтийг хяналтын картаар холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлэлээ.

Аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар 2022 оны хагас жилийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг танилцуулж, тэмдэглэлээр 6 заалт бүхий үүргийг холбогдох байгууллага, нэгж, сумдад хүргүүлэв. Хагас жилийн мэдээг хүснэгтээр харуулбал:

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал /Өссөн дүнгээр/

№	Нэр	Нийт	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Аймгийн ИТХ	18	14	4	0	0	100
2	Аймгийн ЗДТГ	410	360	0	0	50	87,80
3	Сумд	5398	4751	96	108	443	91,79
4	Харьяа агентлаг, хэлтэс	1556	1449	24	8	75	95,18
Нэгдсэн дүн		7382	6574	124	116	568	92,31

Өргөдөл гомдол хэлбэрээр /Өссөн дүнгээр/

№	Нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
1	Аймгийн ИТХ	18	18	0	0	0	0
2	Аймгийн ЗДТГ	410	170	130	50	60	0
3	Сумд	5398	4411	143	130	697	17
4	Харьяа агентлаг, хэлтэс	1556	1502	41	13	0	0
Нэгдсэн дүн		7382	6101	314	193	757	17

Өргөдөл гомдол агуулгаар /Өссөн дүнгээр/

Төв аймаг	<p>Нийт 7382 өргөдлөөс</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүсэлт 7000/ 94.83% 2. Гомдол 245/ 3.32% 3. Санал 137/ 1.85% <ol style="list-style-type: none"> 1. Газартай холбоотой асуудлаар 2297 / 31.12% 2. Иргэний бүртгэлийн чиглэлээр 934 /12.65% 3. Халамжийн үйлчилгээний чиглэлээр 590/ 7.99% 4. Ажил, тусламж хүссэн 473 / 6.40% 5. Нийгмийн даатгалын чиглэлээр 424/ 5.74%
-----------	--

НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын Хүнс, хөдөө, аж ахуйн байгууллага Европын холбооны санхүүжилтээр Монгол улсын хэмжээнд Үр дүнд суурилсан төлөвлөлт болон төсөвлөлтийг нэвтрүүлэх нь сэдэвт сургалтад аймгийн хэмжээнд 124 албан хаагчийн судалгааг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэн сургалтын бэлтгэл ажлыг хангаж байна.

Удирдлагын академиас зохион байгуулж буй улсын төсвөөр болон байгууллагын зардлаар сургах сургалтад аймгийн хэмжээнд 80 гаруй албан хаагчийн судалгаа мэдээллийг нэгтгэн, квотын дагуу хамрагдах албан хаагчийн мэдээллийг хүргүүлэв.

Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрт хамрагдах хүсэлт ирүүлсэн албан хаагчдын мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааныг 2 удаа хуралдуулж, бодлогын хэлтэс, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 81 иргэний тодорхойлолтыг хэлэлцүүлж, холбогдох байгууллагаас дүгнэлт авч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилав.

“Их Монгол улс байгуулагдсаны 815, 816 жил, Ардын хувьсгалын 100, 101 жил, Төв аймаг байгуулагдсаны 99 жил, Зуунмод хот байгуулагдсаны 80 жил, Монгол Улсын дөрөв дэх Ерөнхий сайд Манзушир хутагт Самбадондовын Цэрэндорж, Монгол Улсын төрийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын шадар сайд, бүгд захирах сайд, Дотоод Яамны хэргийг Бүгд Захиран Шийтгэгч яамны тэргүүн сайд Да лам Гомбын Цэрэнчимэд нарын мэлмий гийсний 150 жилийн ойн баяр наадмын зохион байгуулах хороог байгуулж, бэлтгэл зохион байгуулалтыг хангаж ажилласан. 2022.07.29-ний өдөр “Төв түмний цэнгэл” баяр наадмыг Баянцагаан суманд зохион байгуулж, бэлтгэл зохион байгуулалтыг хангаж ажиллав.

7-р сарын 8-ны өдөр Зүүн хойд Азийн Засаг захиргааны “NEAR” холбооны нарийн бичгийн дарга нарын газрын дарга Ким Уг Чэ болон бусад албаны хүмүүс Төв аймагт хүрэлцэн ирж Засаг дара Д.Мөнхбаатар, Засаг даргын орлогч Ц.Буманбуян нартай уулзаж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

7-р сарын 8-ны өдөр Ирланд улсаас БНХАУ-ын Бээжин хотод суугаа Элчин сайд Анн Дервин Төв аймагт айлчлал хийж Төв аймгийн Засаг даргын орлогч Ц.Буманбуян, Төв аймгийн ЗДТГ-ын дарга М.Отгонбат, ТЗУХ-ын дарга С.Магнайбаяр, НБХ-ын дарга Д.Мөнхцэцэг нартай уулзаж цаашид 2 орны хамтын ажиллагааны талаар санал солилцов.

7-р сарын 26-28-ны өдрүүдэд БНСУ-ын Пёнтек хотын Гадаад харилцааны хэлтсийн мэргэжилтнүүд Төв аймагт хүрэлцэн ирж Д.Нацагдоржийн нэрэмжит Төв аймгийн Нийтийн номын сангийн Пёнтек хотын нэрэмжит өрөөг тохижуулан хүлээлгэн өгөв.


Аймгийн веб сайт www.tov.gov.mn, албаны <https://www.facebook.com/tovgov> пейжид Төв аймаг байгуулагдсаны 99 жилийн ойн баяр наадам, Баянцагаан суманд зохион байгуулсан “Төв түмний цэнгэл” баяр наадам болон намрын ургац хураалтын ажил эхлэх гэж байгаатай холбогдуулан УИХ-ын гишүүн Ж.Батжаргал, ЗГ-ын гишүүн ХХААХҮ-ийн сайд З.Мэндсайхан, Засаг дарга Д.Мөнхбаатар нарын газар тариалангийн бүс нутгуудаар ажилласан талаарх мэдээ мэдээлэл, бусад цаг үеийн шинжтэй 71 мэдээ сурвалжлагыг нийтлэн иргэд олон нийтэд хүргэсэн.

Хамтран ажилладаг Өлзий, Сүлд, LIVE, TBS, Төв ТВ-ийн мэдээний цагаар цаг үеийн 20 мэдээг тус бүр нь 2-3 удаагийн давталттайгаар цацаж иргэд олон нийтэд хүргэсэн. Мөн Төв аймаг байгуулагдсаны 99 жилийн ойн баяр наадам, Баянцагаан суманд зохион байгуулсан Төв түмний цэнгэл баяр наадмыг Төв ТВ-тэй хамтран шууд дамжуулсан.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТӨВ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

1. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.1. Салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 57 тогтоол гаргасан бөгөөд дундажаар 93.85%-ийн биелэлттэй байна.



1.2. Салбар зөвлөлд ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдол, СЗ-өөс явуулсан хариутай бичгийн шийдвэрлэлтийг танилцуулбал:

№	Төрөл	Нийт тоо	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн хувь
1	Ирсэн албан бичиг	216	146	142	4	97.26%
2	Ирсэн өргөдөл, гомдол	12		12	0	100%
3	Явсан албан бичиг	109	103	92	11	89.32%

1.3. 27 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны ажилтны албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-ийн зөвшөөрлийн дагуу баталгаажуулах ажилд хяналт тавьж ажилласан.

1.4. 2016-2020 онд аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байсан иргэний судалгааг гаргаж ТАЗ-д хүргүүллээ.

2. Сургалт, мэдээллийн чиглэлээр:

2.1. Өссөн дүнгээр ТАЗ-ийн “7:4:10” цахим сургалтыг 25 удаа зохион байгуулахад холбогдох албан хаагчдыг хамрууллаа.

3. Сонгон шалгаруулалтын чиглэлээр:

3.1. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.6-д заасны дагуу төрийн захиргааны удирдах 9 (ахлах түшмэл-7, дэс түшмэл-2), гүйцэтгэх 151 (дэс түшмэл-131, туслах түшмэл-20), нийт 160 сул орон тоог тусгай шалгалтаар нөхөх захиалгыг ТАЗ-д хүргүүллээ.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:

Д/д	Үйлчилгээний тоо			Үйлчилгээний нэрс	
	Нийт	Төлбөртэй	Төлбөргүй	Нэр	Тоо
1			+	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт	124
2			+	Иргэний оршин суугаа хаягийн бүртгэлийн лавлагаа	75
3			+	Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа	37
4			+	Гэрлэсний бүртгэлийн лавлагаа	20
5			+	Иргэний үнэмлэхийн лавлагаа	14
6			+	Иргэн (Даатгуулагч)-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт	1
7			+	Үл хөдлөх хөрөнгийн жагсаалтын лавлагаа	13
8			+	Гэрлэсний бүртгэлгүй лавлагаа	4
9		+		Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт	18

10			+	Жолоочийн лавлагаа мэдээлэл	2
11			+	Вакцины гэрчилгээ	9
12			+	Кадастарын зураг хэвлэх	1
13		+		Бүрэн боловсролын үнэмлэхийн тодорхойлолт	1
14			+	Төрсний бүртгэл	1
15		+		Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт (иргэн)	14
16		+		Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт (ААНБ)	5
17		+		Төв аймгийн (сумдууд) Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл сунгах	2
18			+	Эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах	2
19			+	Газар эзэмших эрхийн гэрчилгээний лавлагаа	1
12		+		Жолооны үнэмлэх солих нөхөн олгох	4
13				Иргэний даатгалд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үсээгүй тухай тодорхойлолт	1
14				Хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэлтэй эсэх лавлагаа	2
15				Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч хувьцаа эзэмшигчийн тухай лавлагаа	3
16				Авто тээвэр хэрэгслийн торгуулийн мэдээлэл	1

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан нэгдсэн хуваарь, удирдамжийн хүрээнд Хий цэнэглэх станц агуулах, АХЦС-ын барилга байгууламжид Төрийн хяналт шалгалтын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудыг үндэслэн гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт гүйцэтгэлын хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллалаа.

Шалгалтад Төв аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Хий цэнэглэх станц агуулах, АХЦС-ын барилга байгууламжид нийт 4 байгууллага хамрагдсанаас гал түймэр гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй 11 зөрчил илэрснийг цаг хугацаа шаардагдах 3 зөрчилд үүрэг өгч ажиллалаа

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 26 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 134 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 68 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд заавар зөвлөгөөг өгч ажилласан байна.

Ардын хувьсгалын 100, 101, Төв аймгийн 99, Зуунмод хотын 80 жилийн ойн баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан иргэдэд аймгийн хэмжээнд нийтийн хоолоор үйлчлэх цэгүүдэд Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 08/04 дүгээр албан мэдэгдэл “Галын аюулгүй байдлыг хангуулах тухай”-ийг хүргүүлэн ажилласан. Тус албан мэдэгдлийн хүрээнд наадмын талбайд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий 68 нийтийн хоолоор үйлчлэх цэгүүдэд хяналт шалгалт хийж, 123 зөрчил илрүүлж, гаргасан зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж өгсөн.

Аймгийн хэмжээнд баригдах 8 барилгын зураг төслийг хянаж, дүгнэлт бичиж холбогдох дансанд зураг хяналтын 650,000 төгрөгийг төвлөрүүлсэн.

Хяналт шалгалтанд хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 32-н аж ахуй нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрөл олгож ажиллаа.

Онцгой байдлын ерөнхий газраас дэвшүүлсэн зорилт, аюулт үзэгдэл, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр тухайн жилд хийж гүйцэтгэх ажлын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр аймгийн 2022 оны нэгдсэн төлөвлөгөөнд гамшгаас хамгаалах

ангиллын сургалтын хуваарийг оруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэн ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газарт Онцгой байдлын газраас зохион байгуулж буй ангиллын сургалтын СМ-1 мэдээ, урьдчилан сэргийлэх ажлын тоон үзүүлэлтийг цахим хаягт байршуулахаас гадна 7 хоног бүрийн баасан гаригт цаасан хэлбэрээр хүргүүлсэн.

Аюулт үзэгдэл, ослын төрөл тус бүрт урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай алба хаагчдыг бэлтгэх зорилгоор аж ахуйн нэгж байгууллагад ангиллын сургалт зохион байгуулах удирдамж гарган батлуулж, Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгийн алба хаагчид, мэргэжилтэн нартай хамтран ангиллын нийт 5 удаагийн 10 цагийн сургалтыг танхим болон дадлага хэлбэрээр 97 ажилтныг хамруулж, 4 төрлийн 10200 ширхэг гарын авлага тараасан.

Үер усны ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд амрагч зугаалгаар яваа иргэд ихээр байрладаг газруудад 9 төрлийн 36 ширхэг анхааруулах самбарыг 5 суманд байршуулсан.

Гал унтраах өдөр тутмын дасгал сургуулийг Онцгой байдлын газрын даргаар батлуулж батлагдсан төлөвлөгөөний дагуу 24 удаа 48 цагийн дадлагыг давхардсан тоогоор 144 алба хаагчийг хамруулан зохион байгуулж мэргэжлийн ур чадвар авхаалж самбааг дээшлүүлэн ажиллаж байна.

2022 онд зохион байгуулагдах тактик тархалтын сургуулийн төлөвлөгөөг удирдлага болгон Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага сургалтын төлөвлөгөө боловсруулах зааврын дагуу бичиг баримтыг боловсруулан "Андууд худалдааны төв", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар", "Прокурорын газар", "Нийгмийн даатгалын хэлтэс" зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудын обьектод тархалтын сургуулийг зохион байгуулж, аж, ахуй нэгж, байгууллагын 56 ажилтан алба хаагч хамрагдсан.

Орон нутгийн TBS телевизээр цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үед хол замд зорчихгүй байх, бэлтгэл бэлэн байдлаа сайтар хангах, дулаан хувцаслах, баталгаат зам гүүр, маршрутаар явах, Онцгой байдлын байгууллагаас өгч буй заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цаг тухай бүр телевизээр дамжуулан ард иргэдэд өдрийн 3 удаагийн давтамжтайгаар нийт 75 удаа хүргэсэн.

Онцгой байдлын газрын 5200 дагагчтай фейсбүүк хуудсанд 15 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, веб сайтад сэрэмжлүүлэг мэдээг 4 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө зөвлөмжийг 5 удаа, байгууллагын үйл ажиллагаа, сургалт, хяналт шалгалт явуулсан талаарх мэдээ мэдээллийг 8 удаа нийт 17 удаагийн мэдээ мэдээллийг байршуулан иргэдийг мэдээллээр хангасан.

2022.06.21-ний өдөр Баянжаргалан сумын Эрдэнэ багийн "Буурын ухаа" гэдэг газарт Баян-өнжүүл сумын харьяат малчин Г.Адъяагын 61 хониноос Мал амьтаны гол халдварт "Цэцэг" өвчиний шинж тэмдэг илэрсэн тул дээж авч Улсын мал эмнэлэг, ариун цэврийн лабораторид шилжүүлэхэд 2022.06.22-ны өдрийн 22-2320 дугаар хариугаар "Цэцэг" өвчин болох нь тогтоогдсон. Тус сумын Засаг даргын 2022.06.23-ны өдрийн А/90 дүгээр захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоосон.

2022.07.05-ны өдөр Сэргэлэн сумын Хайрхан 2-р багийн "Ногоон дов" гэдэг газар Улаанбаатар хотоос Оюутолгой руу түлш тээвэрлэж явсан иргэн Ц.Шинэбаярын эзэмшлийн хөдөлгөөн үйлдэж явсан 91-86 УБС улсын дугаартай Бэйбэйн норт бенз загварын ачааны автомашин, Өмнөговийн Улаанбаатар чиглэлд хөдөлгөөн үйлдэж байсан 06-57УНУ улсын дугаартай иргэн Л.Нинагийн эзэмшлийн RAV-4 загварын суудлын авто машинтай мөргөлдөж зорчигч-1 иргэн төмөр хийцэд хавчуулагдаж нас барсан тухай дуудлаганд 3 алба хаагч, 1 автомашинтай ажилласан.

2022.07.13-ны өдөр Лүн суманд төвийн багийн "Бетон гүүр" гэдэг газарт Баянхангай сумын харьяат иргэн Ц.Эрдэнэбаатар /21 настай, эрэгтэй/ "Туул" голын усанд осолдсон гэсэн дуудлагыг 15:26 цагт Лүн сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Г.Тэмүүжин мэдээлэл өгсөн.

Онцгой байдлын газраас 4 албан хаагч, 2 автомашин, 1 завь, ар гэрийн 4 хүн, 2 автомашин, 2 морьтой нийт 8 хүн, 3 автомашин, 2 морь, 1 завьтай ажилласан.

Обьектын гал түймрийн 1, ой, хээрийн түймрийн дуудлага мэдээлэл бүртгэгдээгүй.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Газрын даргын тушаалаар батлагдсан хуваарийн дагуу /ковид-19/ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд автотээврийн шалган нэвтрүүлэх цэг, худалдаа үйлчилгээний газрууд, ариутгал халдваргүйтгэлийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагын “Хяналт удирдлагын нэгдсэн систем”-д БОДБХХХ-ийн хяналтын 9 чиглэлээр 10144 аж ахуйн нэгжийн эрсдэлийг үнэлж оруулсан.

Мэргэжлийн хяналтын газраас НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP) “Байгаль орчны засаглал” төслийн дэмжлэгтэйгээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймгийн Прокурорын газартай хамтран сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчдийг чадавхжуулах сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Батсүмбэр сумын иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийн дагуу Батсүмбэр сумын Баянголын Түшээ гүн орчмын газар олголт, ашиглалтын талаар болон, МХЕГ-ын даргын баталсан урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд Батсүмбэр сумын 2021-2022 оны газар олголтын байдалд шалгалт хийгдэж байна

Баянжаргалан сумын Жаргалан 1 дүгээр багийн Засаг дарга Т.Цэрэнхандын өргөдлийн дагуу Баяндэлгэр сумын нутагт ашиглалтын MV-021581 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч “Говийн ертөнц” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага өгч өргөдлийн хариуг газрын даргын 304 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.

Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир усанд хяналт шинжилгээ хийх тухай удирдамжийн дагуу шинжилгээт хяналт хийгдэж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2022 оны 01/53 дугаар “Ой, ан, байгалийн ургамал хууль бусаар бэлтгэх, ангах, барих, худалдаалах, тээвэрлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх” удирдамжийн хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт мод бэлтгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж байна. Хяналт шалгалтын явцад зөрчил гаргасан 1 ААН-д 7 заалттай албан шаардлага, 1 ААН-д 10,0 сая төгрөгийн шийтгэл, 14,2 сая төгрөгийн нөхөн төлбөр оногдуулсан. Шалгалт үргэлжилж байгаа.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 19/37 дугаартай “Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу аймгийн баяр наадмын хурдан морины уралдааны морь унаач хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавин ажилласан. Урьдчилан сэргийлэх хяналт үргэлжлэн хийгдэж байна.

Баталгаажуулалтын хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн барилгад шалгалт хийж, барилгын ашиглалтын төлөв байдлын тухай 1 дүгнэлт, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын байцаагчийн 1 заалт бүхий 1 албан шаардлага боловсруулж хүргүүлж ажиллалаа.

Төв аймгийн Зуунмод сумын Номт 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын захиалгаар “Орхонконструкшн” ХХК-ийн боловсруулсан зураг төслөөр “Ирксибстрой” ХХК-ийн гүйцэтгэж буй 90 айлын орон сууцны барилгын угсралтын гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн 19-06-019/28, 19-07-020/17 дугаартай албан шаардлагуудад тусгагдсан зөрчлийн заалт бүрийг бүрэн арилгаагүй зөрчил илэрч, улсын байцаагчийн үйл ажиллагаа зөрчил арилгах хугацаагаар түр зогсоох тухай хамтарсан акт боловсруулан, хүргүүлж ажилласан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оноос Мөнгөнморь суманд баригдаж буй сургуулийн дотуур байрны барилгын угсралтын ажил, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Сэргэлэн суманд баригдаж буй ахуйн үйлчилгээний төвийн барилгад тус тус хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Нийтийг хамарсан баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээний үеэр урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор хурдан морины уралдааны үеэр морины үүлдэр, стандартын хяналт тавьж ажилласан.

Нийтийг хамарсан баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээний үеэр урьдчилан сэргийлэх зорилгоор Баяндэлгэр, Эрдэнэ, Зуунмод, Мөнгөнморьт сумдын 138 хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулж улсын байцаагчийн 28 заалттай 2 албан шаардлага, 864 заалттай 48 зөвлөмж, үйл ажиллагааг түр зогсоох тухай 1 акт үйлдэж хүргүүлсэн. Хяналт шалгалтын явцад 247 зөрчил, дутагдал илрүүлж, 221 буюу 90.7%-ийг газар дээр нь арилгуулж хадгалалтын хугацаа дууссан, гарал үүсэл тодорхойгүй 24 нэр төрлийн 3.2кг, 184 ширхэг 1.345 мянган төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг хураан авч Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн.

Барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийх тухай 19/12 дугаартай удирдамжийн хүрээнд 8 барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийж зөвшөөрсөн 5, буцаасан 3 дүгнэлт үйлдэж хүргүүлсэн.

Нийтийг хамарсан баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээний үеэр хоол хүнснээс гаралтай халдвар, хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор 70 иргэн аж ахуйн нэгжийн 5 нэр төрлийн бүтээгдэхүүнээс 73 ширхэг дээж авч нян судлалын шинжилгээнд хамруулсан.

Сорилтын нэгдсэн лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 49 дээжинд 137 үзүүлэлт /Гурил гурилан бүтээгдэхүүнд 4 сорьцонд 14, Хоолны 20 сорьцонд 80, гүний усны 6 сорьцонд 18, төвлөрсөн системийн ус 4 сорьцонд 12, Арчдас 10 сорьцонд 10, Агаарын 2 сорьцонд 4, Хөрс 1 сорьцонд 6, Хөгцний /агаар/ 2 сорьцонд 2/ үзүүлэлтээр эрүүл ахуй нян судлалын шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан бөгөөд үүнээс стандартын шаардлага хангаагүй 7 сорьц 7 үзүүлэлт байна.

Эрүүл ахуй химийн лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 11 сорьцонд 77 үзүүлэлтээр /Төмс хүнсний ногооны 6 дээжинд 12 үзүүлэлтээр Гүнийн ус 5 дээжинд 65 үзүүлэлтээр / эрүүл ахуй химийн шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан байна. Үүнээс: эерэг стандартын шаардлага хангаагүй дээж илрээгүй болно.

Ургамлын үр хорио цээрийн лаборатори нь 18 сорьц 19 үзүүлэлтээр (Цагаан будаа 2 сорьц 2, төмс 2 сорьц 3, шар лууван 2 сорьц 2, салат навч 2 сорьц 2, юцай 2 сорьц 2, байцаа 2 сорьц 2, бөөрөнхий сонгино 2 сорьц 2, урт сонгино 2 сорьц 2, шанцай 2 сорьц 2) үзүүлэлтээр хорио цээрийн шинжилгээг хийж сорилтын үр дүнг хугацаанд нь хянаж баталгаажуулж гаргасан. Үүнээс стандартын шаардлага хангаагүй сорьц илрээгүй байна.

Нэгж лабораториудад нийт 78 сорьцонд 233 үзүүлэлтээр шинжилгээг хийж үр дүнг цаг хугацаанд нь хянаж, баталгаажуулан гаргасан. Баяр наадам, бүх нийтийн амралтын өдөр хуушуур болон хорхогны маханд шинжилгээ хийж ажилласан.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Аймгийн хэмжээнд эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр зохион байгуулсан ажлын тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ. Хууль зүйн салбарын 2022 оны хагас жилийн тайланг видео хэлбэрээр бэлтгэн олон нийтэд сурталчиллаа.

Төрийн архивын 161 хөмрөг үүсгэгч байгууллагын мэдээллийг Архивын ерөнхий газрын нэгдсэн программд оруулж нэрийн өөрчлөлт, баримтын мэдээллийг баталгаажууллаа.

Зам хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" нэгдсэн арга хэмжээний хүрээнд цахим орчноор дамжуулан 23.0 иргэнд мэдээлэл сурталчилгааг хүргэж ажиллалаа.

"Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг өөрчлөх тухай" аймгийн Засаг даргын 2022 оны А/350 дугаар захирамжийг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж эхэллээ.

Үндэсний их баяр наадмын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх хугацаанд сахилга дэг журмыг чангатган хариуцлагатай эргүүл жижүүрийг томилон ажиллуулах талаар аймгийн Засаг даргын 2022 оны А/408 дугаар захирамжийг сум байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

ТӨРИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Төрийн архивын эх баримтаас байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 83 иргэний хүсэлтийг хүлээн авч 468 хуулбар хувь, 44 лавлагаа, 104 сан хөмрөгийн 366 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан үйлчилгээ үзүүлж, орон нутгийн төсөвт 415000 төгрөгийг орууллаа.

1 хөмрөгийн 4 хадгаламжийн нэгжийн 566 хуудас баримтын 1186 хүний нэрийг скайнердаж цахим архивын программд шивлээ.

Баримтын нөхөн бүрдүүлэлтээр "Налайх түгээх "ХХК Эрдэнэ сум иргэн Д.Цэцэгсүрэнгийн ахуйн зориулалтай гадна цахилгаан хангамж 2 хадгаламж, "Бест плас" ХХК, Аргалант сумын хөдөө аж ахуйн зориулалтай барилгын гадна цахилгаан хангамжийн 2 хадгаламж, Зуунмод сумын тойргийн нотариатчдын 2021 оны 33 хадгаламж нийт 37 хадгаламжийн нэгжийг бүртгэлээ.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 63.363 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138.247 газар өмчлөх эрхийн 51.847 байна. Нийт

хүлээн авсан мэдүүлэг 894, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу улсын төсөвт 414.0 сая төгрөгийг орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 41 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 15 нэмэлт өөрчлөлт, шинээр 8 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 0, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 18 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 2 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 15 лавлагаа өгч ажиллалаа. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлогоос 13.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 422 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 140 хэргээр буюу 49.6 хувиар өссөн. Гэмт хэргийн илрүүлэлт 50,4 хувьтай, өмнөх оны мөн үеэс 8,9 хувиар өссөн.

Гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-13, албадан саатуулагдсан-9, шүүхээр баривчлагдсан-46 нийт-68 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу эрүүл мэндийн үзлэг хийж хүлээн авч ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хүүхдийн хүчирхийллийн эсрэг архи согтууруулах ундааны хор уршгийг хүүхэд залууст сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх зорилгоор “21x21” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 21 аймгийн төвд “Тоонот рекорд” ХХК-аас зохион байгуулсан урлагийн тоглолтод 56 албан хаагч үүрэг гүйцэтгэлээ.

Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол улсын 815, 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100, 101, Төв аймгийн 99, Зуунмод хотын 80 жилийн ой, Манзушир хутагт Самбадондовын Цэрэндорж, Монгол улсын төрийн нэрт зүтгэлтэн, Да лам Гомбын Цэрэнчимэд нарын мэлмий гийсний 150 жилийн ой баяр наадам, сумдын баяр наадмын хамгаалалтад 199 алба хаагч, Хүй долоо худагт хурдан морины уралдааны хамгаалалтад 10 алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэж олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллалаа.

2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдөр хүртэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 113 жолоочийг илрүүлж, 74 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 39 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэж ажиллалаа.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 4322 жолоочийг 133.3 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 120 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулж зөрчлийг арилгууллаа.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Криминалистикийн шинжилгээ-156, магадлан шинжилгээ-127, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-143, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-892, гарын хээний санг дардсаар баяжуулсан-488, мөрөөр баяжуулсан-64, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-483, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-162, гистологийн шинжилгээ-127 тус тус хийгдлээ.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
7-р сар	217	397	9	605	316	289	52.2
	4587209.8	1945214.5	178844.7	6353579.6	2075095.6	4278484.0	

ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХҮРЭЭНД:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

журам"-ын дагуу Монгол Улсын Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 89.93 хувьтай тайлагнаж ажиллалаа. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 283 заалтын хэрэгжилтээс бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 168 заалт, хэрэгжих шатанд буюу 70 хувьтай 56 заалт, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай 10 заалт, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 4 заалт тус тус байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/300 тоот захирамжаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу сумын хагас жилийн үнэлгээг 16 үзүүлэлтээр үнэлж дүгнэлээ. Үүнээс: А үнэлгээтэй-3, В үнэлгээтэй-13, С үнэлгээтэй -9, D үнэлгээтэй-2 сум байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/436 тоот захирамжаар сумын 2022 оны хагас жилийн дундаж үнэлгээ 79,82 хувьтай дүгнэгдлээ.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/300 тоот захирамжаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хэлтэс агентлаг, харьяа байгууллагын хагас жилийн үнэлгээг 14 үзүүлэлтээр үнэлж дүгнэлээ. Үүнээс: А үнэлгээтэй-13, В үнэлгээтэй-14, С үнэлгээтэй -2 хэлтэс, агентлаг, харьяа байгууллага байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/438 тоот захирамжаар хэлтэс, агентлагийн 2022 оны хагас жилийн дундаж үнэлгээ 89,10 хувь, харьяа байгууллагуудын дундаж үнэлгээ 87,31 хувьтай тус тус дүгнэгдлээ.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/300 тоот захирамжаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу аймгийн Засаг даргын II дахь удаагийн нэрэмжит үзлэгийг хэлтэс, агентлаг, харьяа байгууллагад 7 бүлгийн 32 үзүүлэлтээр үнэлж дүгнэлээ. Үүнээс: А үнэлгээтэй-18, В үнэлгээтэй-8, С үнэлгээтэй -1, D үнэлгээтэй-2 хэлтэс, агентлаг, харьяа байгууллага байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/437 тоот захирамжаар хэлтэс, агентлагийн 2022 оны нэрэмжит үзлэгийн дундаж үнэлгээ 85,65 хувь, харьяа байгууллагуудын дундаж үнэлгээ 84,67 хувьтай тус тус дүгнэгдлээ.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/300 тоот захирамжаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу аймгийн Засаг даргын II дахь удаагийн нэрэмжит үзлэгийг сумдад 8 бүлгийн хүрээнд үнэлж дүгнэлээ. Үүнээс: А үнэлгээтэй -7, В үнэлгээтэй-16, С үнэлгээтэй - 4 сум байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/432 тоот захирамжаар сумын 2022 оны нэрэмжит үзлэгийн дундаж үнэлгээ 75,91 хувьтай дүгнэгдлээ.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө эхний 06-р сарын байдлаар орон нутаг 12193,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 11414,9 сая төгрөг төвлөрүүлж 93,6 хувьтай, 778,1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 2401,3 сая төгрөг төвлөрүүлэхээс 3611,6 сая төгрөг төвлөрүүлж 150,4 хувьтай, 1210,3 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 1268,2 сая төгрөгөөр биелж, 107,5 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Аргалант, Батсүмбэр, Баяндэлгэр, Баянцогт, Борнуур, Мөнгөнморьт, Эрдэнэ, Зуунмод зэрэг 8 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Баян, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцагаан, Баянчандмань, Бүрэн, Жаргалант, Заамар, Сэргэлэн, Сүмбэр, Угтаал, Эрдэнэсант зэрэг 13 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Баянхангай, Дэлгэрхаан, Лүн, Өндөрширээт, Цээл зэрэг 6 сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

2022 оны 6 сарын байдлаар нийт 34633,7 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг аймгийн төсөвт байгууллагууд болон 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Сумдын ИТХ,ЗДТГазрын зардал, ЕБС, СӨБ, ЭМТөв, Соёлын байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтэд 21842,3 сая төгрөг

Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 12791,3 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна

Өр, авлагын талаар:

2022 оны 6-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 150,6 сая төгрөгийн авлага, 446,8 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 319,4 сая төгрөг буюу 71,5 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 23,3 сая төгрөг буюу 5,22 хувь нь гэрэл цахилгааны өр, 39,0 сая төгрөг буюу 8,74 хувь нь тээвэр шатахууны өглөг, үлдсэн 65,1 сая төгрөг буюу 14,5 хувийг бусад өр эзэлж байна.

ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛЛАЛТЫН ХҮРЭЭНД:

Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх дүрмийн дагуу Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2022 онд 48 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталсан ба энэ сард 4 архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон. Зураг төсөл боловсруулах даалгавар нийт 48 боловсруулан баталсан. Энэ сард 3 зургийн даалгавар боловсруулан баталсан. Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах, ерөнхий төлөвлөгөө батлах, ажлын хүрээнд 2022 онд 89 зураг төсөл зөвшөөрөлцсөн. Энэ сард 9 зураг төсөл батлаад байна.

Нийт 48 барилга байгууламжид барилга эхлүүлэх зөвшөөрөл олгон энэ сард 4 барилга байгууламжид олгосон байна. Барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд энэ онд нийт 30 барилга байгууламжийг ашиглалтад оруулсан ба энэ сард 5 барилга байгууламж ашиглалтад орууллаа.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХҮРЭЭНД:

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/772 дугаар захирамжаар батлуулж төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн цахим тендер шалгаруулалтын www.tender.gov.mn системээр батлуулж тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг авсан. Батлагдсан төлөвлөгөөг нийтэд ил тод болгох ажлын хүрээнд www.shilendans.gov.mn, www.tov.gov.mn, www.khural.mn сайтуудад байршуулан ажилласан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 59.469.7 сая төгрөгийн 96 төсөл, арга хэмжээ тусган баталж үүнээс тендер шалгаруулалт зохион байгуулахаар 59,314.7 сая төгрөгийн 85 төсөл, арга байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 40.361.2 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ;
2. Аймгийн Шилжих үлдэгдэлийн хөрөнгө оруулалтын 6.424.6 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ;
3. Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтын 2.742.8 сая төгрөгийн 3 ажил;
4. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5,504.3 сая төгрөгийн 32 төсөл, арга хэмжээ;
5. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1.206.9 сая төгрөгийн 6 ажил;
6. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 608.0 сая төгрөгийн 5 ажил;
7. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын 2022 оны эм, эмнэлгийн хэрэглэл худалдан авах 1.600.0 сая төгрөгийн бараа худалдан авах;
8. Гадаадын хөрөнгө оруулалтын 867.0 сая төгрөгийн 1 ажил

2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах зорилтын худалдан авах ажиллагааны явц:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ:

-38,659.7 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалт явуулснаас 7 төсөл, арга хэмжээнд 36,475.4 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан.

2. Аймгийн шилжих үлдэгдээс хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-2,707.0 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах эрхийг захиалагчдад хүргүүлснээс 13 төсөл, арга хэмжээнд 2,458.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. 270.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулагдах шатанд ажлын 6 хоног хүлээгдэж байна.

3. Аймгийн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

- Замын сангаас 2,742.6 сая, төгрөгийн 3 ажлаас 2,222.6 сая, төгрөгийн төсөвтэй 2022 онд 190.0 сая, төгрөгийн ажил гүйцэтгэх 1 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулагдсан. 120.0 сая төгрөгийн 1 ажлын тендерийн нээлтийг хийж үнэлгээний хороо үнэлгээ хийж ажиллаж байна. мөн 400.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж, нээлтийг 8 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн.

4. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-ОНХСангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс 7 дугаар сарын байдлаар захиалагч байгууллагад нийт 3,249.4 сая, төгрөгийн 24 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулах эрхийг олгосноос захиалагч 2,631.2 сая, төгрөгийн 23 ажилд гэрээ байгуулсан. 80.0 сая төгрөгийн 1 ажилд гэрээ байгуулах шатанд ажлын 6 хоног хүлээж байна.

-Сумын түвшинд үнэлгээний хороо үнэлгээ хийж буй 200.0 сая, төгрөгийн 1 ажил.

-Аймгийн түвшинд зарласан 980.0 сая төгрөгийн 1 ажил, сумдын түвшинд зарласан 150.0 сая төгрөгийн 1 ажил байна.

-Тендер зарлахаар хүлээгдэж буй, ажлын даалгавар, техникийн доторхойлолт, зураг, төсөл, үнэлгээний хороо байгуулагдаагүй 160.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ байна.

5. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

- Нийт 1,206.9 сая, төгрөгийн 6 төсөл, арга хэмжээнд 100 хувь тендер зарлаж, 8 сард тендерийн нээлт хийх 283.0 сая, төгрөгийн 1 ажил байна. Захиалагч байгууллагад 923.9 сая төгрөгийн 5 ажилд гэрээ байгуулах эрх олгосноос 5 ажилд 894.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан байна.

6. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-Нийт 608.0 сая, төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд тендер зарлахаас гэрээ байгуулагдсан 244.0 сая, төгрөгийн 3 ажил, хэлэлцээр хийгдэж буй 300.0 сая төгрөгийн 1 ажил байна. Захиалагчийн шийдвэрээр 64.0 сая төгрөгийн 1 ажилд гэрээ байгуулагдсан.

7. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын эрүүл мэндийн төвийн 2022 онд шаардагдах: 1 төсөл, арга хэмжээ-дотроо нийт 32 багцтай 1,600.0 сая, төгрөгийн төсөвт өртөгтэй бараа худалдан авах тендерийг зарлаж 32 багцад шалгаруулалт хийж, гэрээ байгуулагдсан.

8. Гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

Япон улсын хөрөнгө оруулалтаар Хүмүүн цогцолбор сургуулийн барилгын дотор засварын ажлын тендерийг 2 дахь удаагаа зарлаж, нээлтийг 2022.07.18-нд зохион байгуулсан 6 оролцогчтой үнэлгээний хороо үнэлгээ хийж ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны 03 сарын А/151 дугаар захирамжийн дагуу төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажлыг цахим тайлангийн системээр 27 сумын 230 байгууллагаас 27 сумын 80 байгууллагын тайлан, статистик мэдээг нэгтгэн баталгаажуулж, 75 байгууллагын тайлан мэдээг засварт буцаан ажиллаж байна

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ:

Газар тариалангийн хүрээнд: Аймгийн хэмжээнд 07-р сарын 25-ны байдлаар:

- Үр тариа 76239 га-д тариалахаас 58764 га буюу 77.0 хувь;
- Төмс 9600 га-д тариалахаас 12526 га буюу 130.5 хувь;
- Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судалгааны Хүнсний ногоо 1649 га тариалахаас 1930 га буюу 117.1 хувь;
- Тэжээлийн ургамал 30000 га-д тариалахаас 17219 га-д буюу 57.4 хувь;
- Тосны ургамал 18250 га-д тариалахаас 28035 га буюу 153.6 хувиар хангаж,

жимс, жимсгэнэ шинээр 10.7 га-д, олон наст ургамал 1 суманд царгас 10 га-д тариалалт хийгдэж, аймгийн хэмжээнд 119380 га-д талбайд тариалалт хийгдлээ

“Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судалгааны төв”-тэй хамтран таримлын өвчин, хортон шавьж, мэрэгч амьтдын илрүүлэх, бүртгэх, тархалт, хөнөөлийг тодорхойлох судалгааны ажил, “Хүнсний ногооны урамшууллын журам” сэдвээр сургалт зохион байгуулж, 4 сумын 35 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрагдаж, 17 суманд ажиллаж ХАА-н тасгийн мэргэжилтэнүүд тариаланчидтай хамтран ажиллаж мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажилласан

Мал аж ахуйн хүрээнд: Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 8 суманд 1050 үнээнд зохиомол хээлтүүлэг хийх ажлын явц 70 хувьтай байна. Улсын төсвийн хөрөнгөөр 2000 үнээ, 500 хонинд зохиомол хээлтүүлэг хийх ажилд 11 техникч ажиллаж, 11 сумын 570 үнээнд зохиомол хээлтүүлгийг хийж байна.

“Төв түмний цэнгэл-2022” баяр наадмыг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллаж, 3 насны морьдын сэрвээний өндрийг АВВ-202206-11, 12 дугаартай төхөөрөмжөөр тодорхойлон ажиллав.

Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоол “Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу 2022 онд ноосны урамшууллыг хэрхэн олгох талаар сумдад албан бичгээр чиглэл хүргүүлсэн.

Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хүрээнд: ХХААХҮЯ-ны Сайдын 2022 оны А/163 дугаар тушаалаар батлагдсан ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр 500.0 сая хуваарилагдаж, нийт 4.0 тэрбум төгрөгийн 29 төслийн материал цахимаар хүлээн авч, эхний шатны шалгаруулалтыг зохион байгууллаа.

“Хүнсний аюулгүй байдал- үйлчилгээний чанар” сургалтыг 90 гаруй худалдаа үйлчилгээний эрхлэгчдэд зохион байгууллаа. Хоршоог хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлтэй 8 сумын 16 иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг Монгол банкны хариуцагчийн зээлийн мэдээллийн санд бүртгэлгүй болголоо.

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тохирлын үнэлгээнд хамрагдахаар хүсэлт ирүүлсэн 7 сумдын худалдаа, үйлчилгээний цэг, бүтээгдэхүүний үнэлгээ хийж, нийт 31 аж ахуйн нэгж, иргэний тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгох, сунгах үйлчилгээ үзүүллээ. 8 сумын худалдаа, үйлчилгээний хэмжлийн 3 төрлөөр нийт 672 ширхэг хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажууллаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

БОАЖЯ-ны харьяа Туул голын сав газрын захиргаа, Эрдэнэ сумын ЗДТГ-тай хамтран 07сарын 25-27-ны өдрүүдэд тус суманд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажилагаа эрхэлж буй иргэн, ААН байгууллагын ус ашиглалтын байдалд хяналт тавих, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд 26 амралт, жуулчны бааз, сувиллын газрын ус ашиглалтад зөвлөмж чиглэл өгч, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг танилцуулж, хаягдал усны дүгнэлт гаргуулах тухай хугацаатай албан бичгийг хүлээлгэн өгсөн. Дээрхи 26 иргэн, ААН байгууллагуудаас ус ашиглах дүгнэлт зөвшөөрөлтэй 14, усны тоолуур суурилуулан хэвийн ажиллаж буй 15 ус ашиглагч ажиллаж байна. Мөн тухайн өдрүүдэд үйл ажиллагаагаа түр хаасан байсан 12 иргэн, ААНБ-ын ажилтанд мэдээлэл өгч, цахим сувгаар зөвлөмж чиглэлийг өглөө.

ХОГ ХАЯГДЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны 02 албан даалгавар, А/240 дүгээр тушаал, Зуунмод сумын захирагчийн 05 дугаар албан даалгаварын хүрээнд, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, монгол үндэсний их баяр наадмаар ард иргэдийг цэвэр, цэмцгэр орчинд наадах боломжийг бүрдүүлэх зорилгоор Богдхан уулын дархан цаазат газар, төв суурин газрын ногоон байгууламж, улс болон орон нутгийн чанартай авто зам, голын ай сав дагуу их цэвэрлэгээг аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Тус цэвэрлэгээнд нийт 209 төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын 3785 иргэд оролцож 378,3 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

“Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эвент арга хэмжээ”-ний хүрээнд малчид, иргэдэд аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, аялал жуулчлал эрхлэх боломжийн тухай мэдлэг олгох, сургалтыг 19 сумыг бүсчлэн 5 суманд зохион байгуулж 65 малчин айл өрхийг хамруулсан.

Алтанбулаг суманд “Баянсонгинот” малчдын бүлэг, аймгийн АЖХолбоотой хамтран “Хонины найр” эвент арга хэмжээ зохион байгуулж, 6 сумын 43 малчин айлын төлөөлөл оролцов.

“Төв түмний цэнгэл наадам -2022” эвент арга хэмжээний хөтөлбөрийн дагуу “Хос морьтон”, “Сайхан айраг” тэмцээн зохион байгуулж, сайхан айрагтай сум, хамгийн сайн дэмбээчин, хос морьтон номинациар шалгаруулсан.

ДОЛОО. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

“Эмэгтэйчүүд-Манлайлал” сургалт-зөвлөгөөнийг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Зуунмод хотод зохион байгуулж уг арга хэмжээнд 27 сумын эмэгтэйчүүдийн төлөөлөл оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хүүхдийн хүчирхийллийн эсрэг болон архи согтууруулах ундааны хор уршгийг хүүхэд залууст сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх зорилгоор Тоонот-21 төслийг хэрэгжүүлэгч Тоонот рекордс ХХК-ны хөтөлбөр, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

Үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй “Нүүдэлчин Монгол-2022” Соёлын биет бус өвийн их наадмын I шатны шалгаруулалтыг 7 ай савын төрлөөр 07 дугаар сарын 29-ний өдөр Баянцагаан суманд амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 22 сум оролцлоо. I шатны шалгаруулалтад амжилттай оролцсон шилдэг өвлөн уламжлагчдад II шатны шалгаруулалтад оролцох Батламж гардууллаа.

ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Монголын скаутын холбоо, Хүүхдийн хөгжил, оролцооны үндэсний сүлжээтэй хамтран “Нэгдүгээрт хүүхэд” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монголын Хүүхдийн зөвлөлийн “МАЙХАНТ” чуулганыг Олон Улсын Хүүхдийн Найрамдал цогцолборт зохион байгууллаа. Чуулганд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 404 хүүхэд оролцлоо. Чуулганы үеэр оролцогч хүүхдүүд Монголын хүүхдийн нэгдсэн зөвлөлийн дүрмийг хэлэлцэн батлах, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд үзэл бодлоо илэрхийлж, саналаа өгөхөөс гадна “Найрамдлын илгээлт-2022” хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих уриалгыг боловсруулсан. Майхант чуулганыг зохион байгуулснаар НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай

конвенцийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх гол зарчмуудын нэг болох хүүхдийн оролцох, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахад төр, иргэн, олон нийтийн оролцоо, түншлэлийг бэхжүүлэхээс гадна **МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ЗӨВЛӨЛ**-ийн үйл ажиллагааг улс орон даяар идэвхижүүлж эхэлсэн.



Хүүхдийн тусламжийн утас 108-д 18 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс:

- Бие махбодийн хүчирхийлэл-3
- Үл хайхрах -4
- Бэлгийн хүчирхийлэл-1
- Сэтгэл санааны хүчирхийлэл-9
- Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр (хурдан морь)-1 дуудлага ирсэн байна. Үүнээс 1

дуудлага мэдээллийг бүрэн шийдвэрлэж, бусад дуудлагад хариу үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Баяр наадмын өдрүүдээр 27 сумын хэмжээнд 168 уралдаанд давхардсан тоогоор 6290 уралдаанч хүүхэд оролцож, 45 хүүхэд мориноос унаснаас 44 хөнгөн, 1 хүнд буюу эгэмний ясны цууралттай эмчлэгдэж байна. Эмнэлгийн байгууллагаас 3 хүүхэд эмчилгээ авсан. Гэр бүл хүүхэд, залуучуудын газрын ажлын хэсгээс Төвийн бүс Алтанбулаг, Зүүн бүс Эрдэнэ суманд “Цэцээ гүний хурд-2022”, Баруун бүс Эрдэнэсант суманд “Хатан туулын хурд-2022” дээд гурван насны хурдан морины уралдаанд хяналт тавин ажилласан бөгөөд бүсийн наадамд нийт 381 морь уралдсанаас 6 уралдаанч хүүхэд мориноос унасан. Бэртэл гэмтэл аваагүй.

Насанд хүрээгүй хүнийг болзошгүй гэмт хэрэг, зөрчил, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний Эрсдэлт нөхцөлд байгаа, хараа хяналт дутмаг, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг олж илрүүлэх ажлын хүрээнд Зуунмод сумын 1-р багийн 2 өрх, 3-р багийн 1 өрхөөр орж нөхцөл байдлын үнэлгээ хийж, гэмт хэрэг, хүчирхийлэлд өртөж болзошгүй 5 хүүхдийг илрүүлж, бүртгэлийн санд бүртгэлжүүлсэн. Цаашид 3 хүүхдэд хэсгийн ахлагчийг хяналт тавьж ажиллахыг чиглэл болгон хүүхэд хүлээлгэн өгөх маягтын дагуу мэдээллийг хүлээлгэн өгсөн.

“Хүүхдийн мөнгө” зогсоох тухай 3 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн, 1 хүүхдийн мөнгөний хүсэлтийг сэргээсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хүүхдийн хүчирхийллийн эсрэг болон архи, согтууруулах ундааны хор уршгийг хүүхэд, залууст сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх зорилгоор 21*21 төслийг хэрэгжүүлэн хүүхдийн тусламжийн утас 108-ийг сурталчлах ажлын хүрээнд хүүхдийн хүчирхийллийн эсрэг постер, мэдээлэл, стэндийг бэлтгэн 2022.07.04-ний өдрийн үйл ажиллагааны үеэр Мөнх-Алдарын талбайд хүүхэд, залууст мэдээллийг түгээн, гарын авлага тарааж ажилласан.

Мөн хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчлан гарын авлага тарааж, давхардсан тоогоор 300 гаруй хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн. Арга хэмжээний хүрээнд Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх “Залуу зохион бүтээгч” төвийн багш Н.Баярбат, сурагч Н.Номин нар үзүүлбэр үзүүлсэн.

Төв аймаг дах сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 151\ШЗ2022\02268 дугаар захирамжаар ГБХЗХГ-ыг шинжээчээр томилсон. Захирамжийг үндэслэн Гэр бүлийн хөгжил хариуцсан ахлах мэргэжилтнээр ахлуулсан шинжээчийн багийг томилон, хүүхдийн асаргаа тогтоолгох маргаанд нөхцөл байдлын үнэлгээ хийхээр 2022 оны 07 дугаар сарын 19, 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүрэг болон Алтанбулаг суманд ажиллан, холбогдох дүгнэлтийг Төв аймаг дах сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлж ажилласан.

Аймгийн Цагдаагийн газартай хамтран зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдөр “Гэр бүлийн харилцаа ба хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн үүрэг оролцоо” сэдвээр Цагдаагийн газрын түр саатуулах байранд гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний зөрчлөөр 7-30 хоногоор баривчлагдсан 8 хүмүүжигчид зохион байгуулж ажилласан.

Сэлэнгэ аймгийн ГБХЗХГ-аас 2022.07.20-ны өдөр ирүүлсэн 120 дугаар албан бичгээр “Манаа” асрамжийн газраас М.Амарбаясгаланг гэр бүлд нь эргэн нэгтгэх хүсэлтийн дагуу Жаргалант сум Загдал 4-р багт оршин суух Н.Тэмүүлэнгийн гэр бүлд 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдөр очиж, нөхцөл байдлын үнэлгээ хийн, үнэлгээг хүргүүлсэн.

Долоо хоног бүрийн Баасан гарагийн 17:00 цагт “ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ЦАГ” нэртэй мэдээллийг “Та үүнийг мэдэх үү?”, “Салалтаас зайлсхийхийн тулд анхаарах 8 зүйл” зэрэг 2 сэдвээр бэлтгэн байгууллагын цахим хаягт байршуулж, иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.

Аймгийн Цагдаагийн газартай хамтран гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний зөрчлөөр хариуцлага хүлээж байгаа 28 хүмүүжигчид “Гэр бүлийн харилцаа”, “Хорт зуршиллын сөрөг тал” сэдвүүдээр сургалт зохион байгуулан ажиллалаа.

Залуучуудын хөгжлийн төвөөс Ахмад үеийн үлгэр дуурайлал, сайн туршлагыг залуучуудад сурталчилан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилготой “ЗӨВ ТУСГАЛ” арга хэмжээг Төв аймгийн Эрдэнэсант суманд аймгийн Баялаг бүтээгчдийн холбоотой хамтран П.Базаррагчаа баатрын мал маллагааны шалгарсан арга туршлагаар эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт зохион байгуулж, 70 гаруй малчид оролцсон.

Төв аймгийн Залуучуудын хөгжлийн төв, “Монголын гэр бүл, сайн сайхны нийгэмлэг” Төв аймаг дахь салбартай хамтран “Өглөөний мэнд” клубын эхний уулзалтаа амжилттай зохион байгууллаа. Уулзалтад ГБХЗХГ-ын дарга нар “Цаасан хуйлбар” /quilling/ урлалын тухай танилцуулж, оролцогчид нэг нэг бүтээлтэй болж, шинэ зүйлд шимтэн суралцсан. Малчин залуу гэр бүл хөтөлбөрийн хүрээнд 27 сумаас малчин залуучуудын судалгааг авч нэгтгэсэн. Судалгаанд суурилсан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ: 2022 оны 7 дугаар сарын байдлаар 1896 иргэнд 3572,6 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1216 иргэнд 708,4 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1045 иргэнд 546,8 сая төгрөгийн амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, 22 иргэнд 26,4 сая төгрөгийн онцгой тохиолдолын мөнгөн тэтгэмж, 9701 эхэд 1249,2 сая төгрөгийн “Алдарт эх” 1, 2-р зэргийн одонтой эхийн мөнгөн тэтгэмж, 5743 ахмад настанд 915,2 сая төгрөгийн насны хишиг тэтгэмж, 1138 ахмад настанд 208,2 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 252 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 49,1 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 5438 иргэнд 365,5 сая төгрөг, жирэмсэн 1311 эхэд 137,5 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4411 эхэд 1384,5 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 315 эх /эцэг/-т 128,4 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн 16 ихэр хүүхдэд 32,0 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн

халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 4 иргэнд 6,9 сая төгрөг, 33850 хүүхдэд 20386,5 сая төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 125 иргэнд 5,1 сая төгрөгийг тус тус олгосон.

Нийгмийн хөгжлийн чиглэлээр: Хүүхдийн мөнгө ороогүй банкны КАМ шалгуур хангаагүй 243 хүүхдийн мэдээллийг засч и-халамж програмд бүртгэж хүүхдийн мөнгөний нөхөн олголтыг хийсэн. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 100-с дээш малтай 52 өрхөд хяналт хийх албан тоотыг сумдын амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд илгээж мэдээлэл өгсөн.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 07 дугаар сарын байдлаар 25 ажил олгогч, 59 ажил хайгч иргэн бүртгээд байна. Шинээр бий болсон 38 /нийт 550/ шинэ ажлын байрыг бүртгэн мэдээллийн санд оруулсан. Нийт 23 ажил олгогчийн 86 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 28 /нийт 390/ иргэн ажилд зуучлагдлаа. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдах 32 иргэний, бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг Нийгмийн Даатгалын Хэлтэст хүргүүлсэн. Түр ажлын байранд ажилласан 471 /нийт 5157/ иргэнийг бүртгэж мэдээллийн сан үүсгэсэн.

Оролцоо төсөл: Оролцоо төслийн Эхний шатанд 18 иргэн хамрагдаж 10 иргэн дадлагат гарснаас 4 иргэн дадлагаа бүрэн дуусгаж 3 иргэн дадлага хийхээс өөрийн хүсэлтээр татгалзсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан: Тайлант хугацаанд 12 иргэний 36935,7 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, өссөн дүнгээр 345 иргэний 304726.1 мянган төгрөг төвлөрсөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт тухайн сард Уулс Заамар ХХК 8820,0 мянган төгрөг төлж өссөн дүнгээр 16 иргэний 76984,2 мянган төгрөг төвлөрсөн байна. ХЭДСанд 1051400,0 мянган төгрөгийн санхүүжилт авч 585459,2 мянган төгрөгийг зарцуулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд: Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээний хурлыг Баянхангай, Борнуур, Лүн, Угтаал, Дэлгэрхаан сумдад сумын ажлын хэсэгтэй хамтран танхимаар зохион байгуулж /аймгийн ажлын хэсгийн зарим гишүүд цахимаар оролцсон/ ААЭДХөтөлбөрт 7 иргэний 52,0 сая ₮, ХБИХЭДХөтөлбөрт Угтаал, Борнуур, Дэлгэрхаан сумын 4 иргэний 26,0 сая ₮, АХЭДХөтөлбөрт Лүн, Баянхангай, Борнуур сумын 4 иргэний 12,5 сая ₮-ийн гэрээ хийх боломжтой шийдвэрийг ХХҮГазрын даргад танилцуулан санхүүжилтийг иргэдэд олголоо. Баянхангай, Дэлгэрхаан, сумын 4 малчинд мах, сүү, ноолуурын чиглэлийн 328 толгой бог малыг хүлээлгэн өгч иргэдийн өрхийн амьжиргаанд 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг ХЭДСангаас зарцууллаа.

ХЭДСангийн санхүүжилтээр бизнесийн үйл ажиллагаа явуулж буй иргэдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах Зуунмод сумын “Төв Керамик” компанийн борлуулалтын цэгт 600,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд 7 сумын 12 бизнес эрхлэгчийн 12,8 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулж, иргэдэд дэмжлэг үзүүлээ. Ахмадын ХЭДХөтөлбөрийн хүүхэд хамгаалагч арга хэмжээнд хамтран ажиллаж буй 2 иргэний сарын ажлын тайланг хүлээн авч, 560,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн цахим сургалтад Заамар, Батсүмбэр, Архуст, Баянчандмань, Зуунмод сумын 18 эмэгтэй хамрагдан, нягтлан бодох бүртгэл суурьтай мэргэжлийн ур чадварын сургалт, хувь хүний хөгжлийг дэмжсэн хөдөлмөрт бэлтгэх сургалт, цахим орчинд бизнесийн талбараа нээж, хөтлөх ур чадварыг эзэмшихээр Сонор сургалтын төвтэй хамтран ажиллаж байна. Сургалтад хамрагдаж байгаа эмэгтэйчүүдийн хувьд бага насны 2-6 хүүхэдтэй бөгөөд ажилд зуучлагдах боломжгүй, хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй ажилгүй ээж нар байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 3 өргөдөл, гомдол, 7 албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч ажилласан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтын газраас хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж “Нийгмийн даатгалын тухай хууль”-д заасан болзлоор малчин, хэвийн бус нөхцлөөр тэтгэвэр тогтоолгохдоо хуурамч материал бүрдүүлсэн байж болзошгүй 14 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийг шалгуулахаар Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн. Шалгах ажиллагаанд хяналт тавиулахаар Прокурорын газарт хүсэлт гаргасан.

Хэлтсийн даргын баталсан 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хяналт шалгалт

хийх” ажлын удирдамжийн дагуу 2022 оны 1-5 сарын нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа, төсөвт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт шалгалт хийхэд төсвийн гүйцэтгэлийн зарлагын 2022 оны 05 дугаар сарын мэдээгээр нийгмийн даатгалын сангаас урсгал санхүүжилтээр 401,6 сая төгрөг зарцуулахаас 401,7 сая төгрөгийг зарцуулж 0,1 сая төгрөгийг илүү зарцуулж ажилласан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд шалгалт хийхэд: 2022 оны 05 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын сан болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 123 мэдээлэл байршуулахаас 63 мэдээллийг хугацаа хоцроосон, 5 мэдээлэл байршуулаагүй, бусад мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулсан байна.

Нийгмийн даатгалын сан болон үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлтэй холбоотой мэдээ, мэдээлэл, тайланг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн дүнгээс харахад мэдээ, тайланг 76,4 хувьтай хугацаанд нь байршуулж мэдээлсэн байна.

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-д зааснаар иргэний нэхэмжлэлтэй шүүх хуралд хяналт шалгалт, дотоод аудитын тасгаас 5 удаа нийгмийн даатгалын хэлтсийг төлөөлж гуравдагч этгээдийн үүргээр татагдан оролцсон.

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 2 удаа 12 цаг хуралдаж, нийт 120 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 26 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 87 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 7 иргэнийг цуцалсан байна.

Жирэмсэн амаржсаны тэтгэмж 666 даатгуулагчид 1,126.1 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 1046 даатгуулагчид 139.8 сая, ажилгүйдлийн тэтгэмж 290 даатгуулагчид 660.5 сая төгрөг тус тус олгосон байна. Хаан банк болон Төрийн банкаар дамжуулан 17347 тэтгэвэр авагчдад 8,3 тэрбум төгрөгийн тэтгэврийг аймгийн хэмжээнд олгон ажилласан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн хэмжээнд 2022 оны 7 дугаар сарын байдлаар 398 эх амаржиж өнгөрсөн оны мөн үеийнхээс 183 тохиолдлоор буурсан ба 403 нярай бүртгэгдсэн байна. Жирэмсний хяналтад нийт 707 эмэгтэй байна, 669 жирэмсэнг шинээр хяналтад авснаас эхний 3 сартай хяналтад 91.93% хамрагдсан. Нийт 171704 хүнд үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 63629, амбулаторийн үзлэг 86806, идэвхитэй хяналтын 14260 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 8650 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 24.96%, осол гэмтлийн дуудлага 2.61%-ийг эзэлж байна. Стационарт 9583 хүн эмчлэгдэн нийт 72293 ор хоног ашигласан байна. Дундаж ор хоног 7,5 байна.

7 дугаар сард Ковид-19 халдварын 112 тохиолдол бүртгэгдсэн ба Коронавируст халдварын тандалт судалгаа хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулсан.

Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд нийт 15359 иргэн хамрагдаж ehospital програмд баталгаажсан байна. Үүнээс эрэгтэй 7699, эмэгтэй 7660 байна. 0-5 насны хүүхэд 1667, 6-17 насны хүүхэд 12787, 18-30 насны иргэн 341, 30-аас дээш насны иргэн 564 хамрагдсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 8 хүүхдийг АНЭ-ийн хүүхдийн эмчийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж Сэргээн засах үндэсний төвийн нарийн мэргэжлийн эмчид үзүүлэн, хэвтүүлэн эмчлүүлэхээр захиалга өгөөд байна.

Эх барих, хүүхдийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай ургийн хяналтын монитор, инкубатор, сэхээн амьдруулах ширээ, 9.3 сая төгрөгийн үнэ бүхий хяналтын монитор, вакцины хөргөгчийг НҮБ-ын ХАСангаас аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүлээлгэн өгсөн.

Аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох 3 дугаар хурлыг хуралдуулан, 2022 оны 07 дугаар сард тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаж байгаа төрийн 24 эмнэлэг, 20 эмийн сан, 2 хувийн эмнэлэг, 4 хувийн эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааг сунгаж, МЭИК-ны харьяа Төв эм хангамж ХХК-ны ажлын байранд дүгнэлт хийсэн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нарын дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэсэн.

2022 оны төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн тайлан гаргаж, 2023 оны төсвийн төслийг АНЭ, өрх, сумын Эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэж байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан 4 хүнд мөнгөн тэтгэмж олгосон.

Төв аймгийн Эрүүл мэндийн газар, Сөүлийн эрүүл мэндийн сайн дурын сантай байгуулсан харилцаа, хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд БНСУ-ын шүдний нарийн мэргэжлийн эмч нар, сайн дурын ажилтнууд Зуунмод суманд ажиллаа. Аймгийн ИТХ-ын дарга, АЗДТГ-ын НБХ-ийн дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Нэгдсэн эмнэлгийн дарга нартай уулзаж хамтын ажиллагааны хүрээнд цаашид зохион байгуулах үйл ажиллагааны санал солилцлоо. Шүдний эмч нар хүүхдүүдэд амны хөндийн эрүүл ахуйн сургалт зөвлөгөө өгч, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг дадлага, туршилт хэлбэрээр зохион байгуулж, Зуунмод сумаас 128 хүүхэд хамрагдаж амны хөндийн эрүүл ахуйн мэдлэгтэй болсон.

Япон улсын Нагоя их сургуулийн Анагаахын төгсөлтийн сургууль, Эрүүл мэндийн удирдлагын тэнхимийн профессор, АУ-ны доктор Эйко Яамамото, Эх барих, эмэгтэйчүүд, Нярай судлалын холбооны тэргүүн нар ЭМГ, Нэгдсэн эмнэлэг болон Баруун-Зуунмод ӨЭМТ-ийн удирдлага, эх барих, эмэгтэйчүүд болон ерөнхий мэргэжлийн их эмч нар, эх баригч нартай “Умайн хүзүүний эрт илрүүлэгийн өнөөгийн байдал, цаашид хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэл” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулан, ажлын байран дээр зөвлөн тусалж ажилласан.

Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны зохион байгуулалтын талаар АНЭ-ийн Дэмжих төвд дэмжлэгт хяналт хийж, хяналтын мөрөөр засаж сайжруулах ажлыг ЭМГ-ын даргын 4/05 тоот 8 заалт бүхий албан даалгавраар үүрэгжүүллээ.

8 сумын эрүүл мэндийн төвийн дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, Коронавируст халдвартай тэмцэх сэргийлэх салбар төлөвлөгөөний төслийг сумын онцгой комисст танилцууллаа. Мөнх халдварт өвчний 10 голомтод ажиллан, 825 мкв талбайд голомтын халдваргүйжүүлэлт хийж, зөвлөгөө өгсөн.

07 дугаар сард эрүүл мэндийн салбарын хэмжээнд танхимын сургалт 2 удаа 46, цахим сургалт 2 удаа 229 эмч эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамруулан чадавхжуулж, хурал хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулж 121 хүн хамрагдсан.

Улирлын онцлог байдалд тохируулан Үер усны аюулаас урьдчилан сэргийлье, Хоолны хордлогот халдвараас сэргийлье, Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлье, Харшлаас сэргийлье зэрэг мэдээллүүд, Коронавируст халдварын шинэ дэгдэлтийн тухай албан байгууллагуудад зориулсан зөвлөмж боловсруулан, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй бүх албан байгууллагуудад хүргүүлсэн.

Коронавируст халдварын өдөр тутмын болон долоо хоногийн тойм мэдээлэл, Омикроны дэд хувилбар, Коронавируст халдварын нэмэлт тун, 5-11 насны хүүхдийн дархлаажуулалтын тухай иргэдэд зориулсан зөвлөмж гаргаж, постер хийж ЭМГ болон сум, өрхийн ЭМТ-ийн цахим хуудсаар тогтмол иргэдэд хүргэж байна.

Гэдэсний халдварт өвчин, Хоолны хордлого, Хачигт халдвар, Сармагчны цэцэг өвчин, Коронавируст халдварын зөвлөмжийг АНЭ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тооцоог нийлж, гэрээт 77 ЭМБ-н тооцоо нийлсэн акт, тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн. Төв аймаг дахь Цагдаагийн газарт 16 иргэний ЭМД-ын сангаас хөнгөлөлттэй авсан тусламж үйлчилгээний судалгааг гаргаж албан тоотоор хариуг хугацаанд нь хүргүүлсэн.

Утсаар нийт 28 иргэнд ЭМД-н шимтгэл төлөлтийн лавлагаа харж өгч, урьдчилан сэргийлэх үзлэгтэй холбоотой зөвлөгөө өглөө. Цахимаар болон биеэр ирсэн 12 иргэний төр хариуцахын ногдуулалтыг оруулж ЭМД-ын шимтгэл төлөлт шалгах, шимтгэлээ төлөх талаар зөвлөгөө өгсөн.

7 дугаар сарын 04-07-нд 2022 оны ЭМДҮЗ-ийн 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх онлайн сургалт, Ахисан түвшиний Жендэрийн дүн шинжилгээ цахим сургалтад мэргэжилтнүүд бүрэн хамрагдсан.

Аргалант СЭМТ-ийн шинээр ажилд орсон 3 эмчид Google Meet-р “ЭМД-н санхүүжилт”-ын талаар сургалт хийж чиглэл өгч анхан шатны маягтуудад нэмэлт хяналт хийж зөвлөгөө өгсөн. ЭМД-ын шимтгэл төлөлттэй холбоотой 280, урьдчилан сэргийлэх үзлэгийн 420 нийт 700 ширхэг гарын авлагыг гэрээт 77 ЭМБ-д тараасан.

14 ЭМБ-ын эмч нарт утсаар E-Hospital программ, хурууны хээ бүртгэгдэхгүй шалгуур, ковидын санхүүжилтийн талаар зөвлөгөө өгсөн.

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР

Баяр наадмын бэлтгэл ажлыг хангах, төв цэнгэлдэх хүрээлэнгийн зам талбайг засварлах ажлыг албан хаагчдын хүчээр хугацаанд нь хийж дуусгасан.

Ардын хувьсгалын 101, Төв аймаг байгуулагдсаны 99, Зуунмод хот байгуулагдсаны 80 жилийн ойн их баяр наадмаар БТС-ын салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтан албан хаагчид Ардын хувьсгалын 100 жилийн ойн медаль, Аймгийн “Хүндэт тэмдэг”, Аймгийн Засаг даргын “Хүндэт жуух бичиг”-ээр шагнагдлаа.

Өсвөрийн шигшээ багийн тамирчдын бэлтгэл сургуулилтийг чанаржуулах, тасралтгүй үргэлжлүүлэх зорилгоор жү-до бөх, цана, дугуй, волейболын тамирчдыг зуны нэгдсэн бэлтгэл сургуулалтад гаргалаа.

Ламын овооны 32 жилийн ойн их тахилга наадмыг 2022.07.02-нд Манзушир хийдтэй хамтран зохион байгуулж 16 бөхийн барилдаанд Аймгийн харцага Б.Жамсрандорж түрүүлж, аймгийн начин И.Баасанцэнд үзүүрлэлээ.

Аймгийн үндэсний спортын VII их наадмын хүрээнд зохион байгуулагдсан ширээний шагайн тэмцээнийг 2022.07.06 зохион байгуулснаар охид 9, хөвгүүд 8, нийт 17 хүүхэд хамрагдлаа.

Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол улсын 815, 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100, 101, Төв аймгийн 99, Зуунмод хотын 80, Монгол улсын дөрөв дэх Ерөнхий сайд Манзушир хутагт Самбадондовын Цэрэндорж, Монгол улсын төрийн нэрт зүтгэлтэн, Монгол улсын шадар сайд, бүгд захирах сайд, Дотоод Яамны хэргийг Бүгд Захиран Шийтгэгч яамны тэргүүн сайд, Да лам Гомбын Цэрэнчимэд нарын мэлий гийсний 150 жилийн ойн баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд 128 бөх, үндэсний сурын харваанд насанд хүрэгчид 102, хүүхдийн харваанд 28 харваач, шагайн харваанд 10 сумын 17 багийн 136 харваач оролцлоо. Үндэсний сурын харваанд Булган аймгийн Могод сумын уугуул Хилчин Спорт хороо, Есүхэй мэргэн клубын залуу харваач Батбаярын Мөнхжин 32 оноогоор 5-р байрт шалгарса тул аймгийн Засаг даргын 2022 оны 07-р сарын 09-ны өдрийн А/415 тоот захирамжаар Аймгийн “ТОД” харваач цол хүртлээ.

Төв аймгийн Эрдэнэсант сумын харьяат, Дүнжингарав дэвжээний бөх, аймгийн харцага Н.Дашдаваа 7 даван түрүүлж “Аймгийн арслан” цол, Төв аймгийн Заамар сумын харьяат, Дүнжингарав дэвжээний бөх, аймгийн харцага Л.Даваажамц үзүүрлэж “Аймгийн заан” цолны болзол хангалаа. Төв аймгийн Баянхангай сумын харьяат, Дүнжингарав дэвжээний бөх, сумын заан Э.Чойням, Төв аймгийн Өндөрширээт сумын харьяат, Дүнжингарав дэвжээний бөх, сумын заан Х.Шинэбилэг нар шөвгийн дөрөвт шалгарч “Аймгийн начин” цол хүртлээ.

Үндэсний их баяр наадмын шагайн харваанд МУ-ын хошой мэргэн цолоор Бүрэн сумын харваач Ц.Бархүү, МУ-ын мэргэн цолоор Аргалант сумын харваач П.Пүрэвцэрэн, Ц.Цэнд, Т.Баяраа, Ө.Лхагвадорж, И.Дашдорж, П.Цогоо, Жаргалант сумын харваач М.Чинзориг нар амжилттай оролцож Монгол улсын “Мэргэн” цолны болзол ханган үнэмлэх тэмдэгээ гардан авлаа.

Үндэсний их баяр наадмын шагайн харвааны ахмад баг МУ-ын дархан мэргэн Д.Дамбапэлжээ ахлагчтай баг амжилттай оролцож тэргүүн байр, баяр наадмын хүүхдийн сурын харваанд Төв Зуунмод сумын уугуул, 100-н мэргэн холбооны харваач Н.Ариун-Эрдэнэ 2-р байр, Б.Сүхбат 3-р байр, Төв “Эрхэт 3 түрүү багийн харваач У.Өнөрбаяр 3-р байруудыг тус тус эзэлсэн амжилт үзүүллээ.

Бахрайны Манама хотод болсон өсвөрийн чөлөөт бөхийн “U15” Азийн аварга шалгаруулах тэмцээнд 62 кг жинд тамирчин Ү.Мөнхчимэг мөнгө, “U20” ангилалд 86 кг жинд Н.Батбилгүүн мөнгө, 50 кг Э.Золжаргал хүрэл медалийн эзэн боллоо.

2022.07.18-21-нд Тайланд улсын Бангкок хотод болсон жүдо бөхийн 2022 оны өсвөр үе, залуучуудын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд Чандмань Оргил дэвжээнээс 3 тамирчин эрхээ авч оролцсоноос өсвөрийн охидын 70 кг жинд Б.Арвин хүрэл медаль залуучуудын насны эмэгтэй 57 кг жинд Д. Номин шагналт 5-р байр, өсвөрийн хөвгүүдийн 73 кг жинд барилдсан Б.Мөнх-эрдэнэ 7-р байранд орлоо.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, 2023 оны төсвийн төслөө хийж БШУЯаманд, Төрийн болон төрийн бус өмчийн хэлбэрийн 31 сургууль, 40 цэцэрлэг, Албан бус насан туршийн боловсролын төвийн 2023 оны төсвийн төслийг авч нэгтгэн Боловсролын ерөнхий газарт хүргүүлээд байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын тооллогыг хийж Орон нутгийн өмчийн газарт нэгтгүүлсэн. “Оюунлаг Төв аймаг”, “Хичээл судлагдахуун бүрээр сургалтын чанарыг дээшлүүлье-VI” аяны хэрэгжилтийг Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Насан туршийн боловсролын талаар:

Орон нутгийн өмчийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу байгууллагын эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг Албан бус насан туршийн боловсролын төвийн захирлын 2022 оны А/05 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 4 дансны нийт 29 төрлийн 73581770 төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

СОЁЛ, УРЛАГИЙН ТАЛААР:

Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол улсын 815, 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Монгол улсын дөрөв дэхь ерөнхий сайд, манзушир хутагт Самбадондовын Цэрэндорж, Монголын төрийн нэрт зүтгэлтэн Монгол улсын шадар сайд, дотоод хэргийг бүгд захирагч яамны тэргүүн сайд да лам Гомбын Цэрэнчимэд нарын мэлмий гийсний 150 жилийн ой, Төв аймаг байгуулагдсаны 99 жил, Зуунмод хот байгуулагдсаны 80 жилийн ойн баяр наадмыг аймгийн ЗДТГ, Зуунмод сумын ЗДТГ-тай хамтран 07 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй “Нүүдэлчин Монгол-2022” Соёлын биет бус өвийн их наадмын I шатны шалгаруулалтыг 7 ай савын төрлөөр 7 дугаар сарын 29-ний өдөр Баянцагаан суманд амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 22 сум оролцлоо.

Соёлын салбарын төсвийн шинэчлэлийн хүрээнд 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөлөл, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг 27 сумын Соёлын төв, Музей, Монгол туургатан театр, Нийтийн номын сангаас авч нэгтгэн, Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүллээ.

Нийтийн номын сан:

Нийтийн номын сан нь 7 дугаар сард танхимаар 20 байнгын уншигч, 101 ирэгсэд, нийт 247 уншигчдад ном олгож үйлчилсэн байна. Нийт 20 уншигч шинээр карт нээлгэснээс 3 эрэгтэй, 17 эмэгтэй уншигч байна.

Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөдөө орон нутгийн алслагдсан багийн иргэдэд үйлчлэх тоо, чанарыг ахиулах ажлын хүрээнд Бүрэн, Дэлгэрхаан, Өндөрширээт сумын Соёлын төвийн номын санчтай хамтран нийт 75 номыг 2 сарын хугацаатайгаар “Зөөврийн номын сан”-ийн үйлчилгээг хүргэсэн. 07 дугаар сард 102 иргэнд 149 номоор үйлчилсэн байна.

Нийтийн номын сангийн “Насанд хүрэгчдийн уншлагын танхим”-д “Монгол наадам” сэдэвчилсэн номын үзэсгэлэнг сан хөмргийн төрөл анги болон уран зохиолын 36 номоор гаргаж 42 уншигчдын хүртээл болгосон.

2022 оны 7 сард төсвөөр 872.700 төгрөгийн 46 ширхэг ном авч ном, хэвлэлээр сан хөмрөгөө баяжуулан бүртгэлд авч, электрон каталогт оруулан уншигчдын хүртээл болгосон.

Тогтмол хэвлэлийн хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж “ӨДРИЙН СОНИН”-г 6 багц, “ЗУУНЫ МЭДЭЭ”-г 6 багц болгон сараар нь багцалж нийт 12 нэгж болгож иргэд уншигчид мэдээлэл авах нөхцөл боломжийг бүрдүүллээ.

Нийтийн номын сангийн онцлох ажлуудыг иргэдэд сурталчлах зорилгоор байгууллагын ИНФОГРАФИК-ийг 2022 оны хагас жилийн байдлаар гаргаж цахим хуудас <http://library.to.gov.mn> сайт, Facebook page хуудсанд байршуулан иргэдэд хүргэлээ.

Нийтийн номын сан нь Баянхошуу 3-р баг, Зүүндэлгэр 4-р багтай хамтран "ЗУГААТАЙ ЗУНЫ ХӨГЖИЛТЭЙ УНШЛАГА" арга хэмжээг хүүхэд багачуудын дунд амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд “Номын уншлага” хийж Үлгэрийн ном, Оюун ухаан, Танин мэдэхүй, Адал явдалт номнуудыг уншиж, дүгнэлт хийн утга санааг хамтран ярилцлаа. Уншигч хүүхдүүддээ зориулан Шанага долоон одны домог, Үнэг Тогоруу хоёр, Ухаантай хүү, Алтан Шувуу зэрэг үлгэрүүдийг дэлгэцээр үзүүлж, үлгэрээс авах сургамж, эерэг ба эсрэг дүрүүдийн тухай харилцан ярилцсан.

Мөн “АХА” тэмцээн, эвлүүлдэг “PUZZLE” зэрэг тоглоомыг хүүхдүүдийн дунд зохион байгуулахад мэдлэг оюунаа уралдуулан баг хамт олноороо идэвхитэй оролцож байлаа. Арга хэмжээнд оролцсон насанд хүрэгчид болон хүүхдүүдэд номын сангийн уншигчийн картыг үнэгүй нээсэн. Нийт 99 уншигч хүүхэд багачуудыг хамруулаад байна.

“Цахим мэдээллийн танхим”-аас уншигч хүүхэд залуучууд, иргэдэд зориулан Номын сангийн үйл ажиллагаа, цахим сан хөмргийн сурагчдын заавал унших ном, үлгэр болон мэдээ мэдээллийг Нийтийн номын сангийн Facebook page цахим хуудсанд 49 мэдээ мэдээллийг байршуулан олны хүртээл болгож 9078 хандалт авсан байна.

Монгол Туургатан театр:

7 сарын 08-10-ны өдрүүдэд аймгийн баяр наадмын хүндэтгэлийн тоглолт, баяр наадмын нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

7 сарын 29-нд Төв аймгийн Баянцагаан суманд болсон “ТӨВ ТҮМНИЙ ЦЭНГЭЛ-2022” баяр наадмын арга хэмжээнд оролцлоо.

Аймгийн Музей:

7 дугаар сард нийт 2071 иргэнд Музейн үзүүлгээр үйлчилсэнээс 1461 нь хүүхэд, 610 нь том хүн байна.

Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас 07 дугаар сарын 07-ны өдөр Музейн удирдлага, мэргэжлийн болон харуул хамгаалалтын ажилтнуудад “Музейн аюулгүй байдлыг хангах нь” сургалтыг цахимаар зохион байгуулсан. Энэ сургалтад Музейн нийт 8 албан хаагч хамрагдсан.

Манзушир дахь Түүх соёлын үл хөдлөх дурсгалууд болон Шашны, Байгалийн салбар Музейн үзмэрийг оролцуулан “Телескоф интертаймент ХХК”, “Монгол туургатан театр”-тай хамтран “Виртуал үзэсгэлэн” бэлтгэн аймгийн Музейн Facebook page цахим хуудсаар дамжуулан баяр наадмыг тохиолдуулан иргэдэд хүргэсэн. Уг цахим үзэсгэлэнг 7 сард 488 иргэн үзсэн байна.

“Нүүдэлчин Монгол-2022” Соёлын биет бус өвийн их наадмын Гар урлалын үзэсгэлэнг зохион байгуулсан.

Сумдын Соёлын төв:

27 сумын Соёлын төв давхардсан тоогоор нийт 25000 орчим иргэнд 81 төрлийн арга хэмжээг (давхардсан тоогоор) хүргэж үйлчиллээ. 27 сумын Номын сангууд 671 байнгын уншигч, 439 ирэгсэд, 25 иргэнд шинээр карт нээж, 1917 номоор үйлчилгээ үзүүллээ.

НАЙМ. ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД:

Нэг. Их Монгол улс байгуулагдсаны 815,816 жил, Ардын хувьсгалын 100,101 жил, аймаг байгуулагдсаны 99 жил, Зуунмод хот байгуулагдсаны 80 жил, Үндэсний их баяр наадмын хурдан морины комисст орж ажилласан.

Хоёр. Төв аймгийн Баянцагаан суманд 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан “ТӨВ ТҮМНИЙ ЦЭНГЭЛ” баяр наадмын хурдан морины салбар хооронд ажилласан.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР